



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2021

Э-сонин

03-Р САР

92-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.03.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	14,909,253,953.57
Хувьцаа /хоёрдогч/	10,641,587,524.26
Багцын арилжаа	3,761,639,000
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	108,079,149
ХБҮЦ /анхдагч/	4,000,000,000.00
ХБҮЦ /хоёрдогч/	120,603,000.00
Компанийн бонд /хоёрдогч/	38,984,280
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	61,738,157
Хувьцаа /хоёрдогч/	60,734,042
Багцын арилжаа	35,034,060
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	993,429
ХБҮЦ /анхдагч/	10,000
ХБҮЦ /хоёрдогч/	299
Компанийн бонд /хоёрдогч/	387
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	12,608


TOP-20 индекс




Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



MSE B индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	186
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	159
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	126
Компанийн бонд	1
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	16
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.03.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	АРД СЕКЮРИТИЗ ХХК	27,219,926	19,368,710,828	21,522,866	12,660,417,868	32,029,128,695.47
2	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	20,151,289	864,636,772	21,832,792	6,035,621,817	6,900,258,588.62
3	БУМБАТ-АЛТАЙ ХХК	2,269,494	921,673,793	2,711,751	1,096,066,531	2,017,740,323.98
4	БИДИСЕК ХК	2,205,308	516,830,039	6,414,137	1,018,398,391	1,535,228,429.86
5	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	2,962,365	634,497,276	2,313,259	595,266,691	1,229,763,966.75
6	ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК	2,384,637	389,215,423	1,726,150	701,266,334	1,090,481,756.59
7	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	3,174,648	473,985,707	2,863,891	466,478,586	940,464,293.50
8	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	1,594,487	347,157,344	2,510,329	490,655,982	837,813,325.99
9	ГАҮЛИ ХХК	178,880	226,486,707	338,910	190,977,270	417,463,976.78
10	ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ХХК	15,728	15,150,361	114,141	382,749,750	397,900,111.73
11	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	444,645	156,586,608	455,856	186,621,054	343,207,662.35
12	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	1,133,652	131,170,652	2,223,345	145,897,380	277,068,032.57
13	ГҮҮДСЕК ХХК	1,067,134	186,561,871	528,511	87,650,234	274,212,105.11
14	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	3,517,954	154,908,573	1,253,118	54,050,265	208,958,838.41
15	БАТС ХХК	2,238,131	111,959,920	577,547	84,028,569	195,988,488.35
16	МОНСЕК ХХК	228,843	71,751,613	452,096	90,513,147	162,264,760.85
17	ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ХХК	150,676	49,138,552	789,772	67,785,684	116,924,235.12
18	МАСДАК ХХК	22,847	5,487,267	55,293	110,221,290	115,708,556.90
19	ТЭНГЭР КАПИТАЛ ХХК	122,386	99,898,217	32,697	11,189,346	111,087,563.34
20	ЦЕНТРАЛ СЕКЮРИТИЙЗ ҮЦК	40,576	27,512,667	1,284,240	61,545,152	89,057,818.33

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.03.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,475,859	14,177,793,085.00	11,100.00	8,120.00	-3.78
2	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	19,119,893	4,450,148,766.13	311.30	166.21	15.83
3	AIC	АРД ДААТГАЛ ХК	1,165,207	1,652,118,043.00	1,500.00	1,150.00	2.39
4	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	3,857,783	833,875,497.49	260.00	143.00	55.90
5	APU	АПУ	853,909	636,373,112.62	765.00	725.06	2.23
6	MRX	МЕРЕКС	18,720,740	396,963,119.07	25.00	22.00	8.22
7	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	6,796,369	294,096,390.80	46.91	39.10	-0.29
8	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	168,425	281,275,682.20	1,999.00	806.00	109.17
9	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	3,911,711	254,664,770.13	71.30	61.00	-2.64
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	33,641	252,335,785.00	7,950.00	7,020.00	-6.73
11	MFC	МОНОС ХҮНС	3,339,302	229,197,404.55	74.00	64.00	10.45
12	INV	ИНВЕСКОР ББСБ	46,137	139,249,747.00	3,320.00	2,850.00	11.91
13	GOV	ГОВЬ	540,707	130,950,286.15	249.80	226.00	1.31
14	NEH	ДАРХАН НЭХИЙ	4,627,848	122,132,052.36	33.00	19.50	46.41
15	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН ХК	126,879	121,638,908.56	980.00	925.00	-6.23
16	TUM	ТҮМЭН ШУВУУТ	538,666	115,522,491.97	224.00	205.00	-0.02
17	SUU	СҮҮ	493,615	103,717,341.32	216.00	204.00	-1.47
18	RMC	РЕМИКОН	2,863,141	78,436,931.17	33.80	22.00	42.03
19	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,017,211	71,178,743.26	77.00	67.00	-8.00
20	SHG	ШАРЫН ГОЛ	85,543	68,496,325.39	980.00	756.00	5.57



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /%/
			2021-02-28	2021-03-31		
1	БЭРХ УУЛ	198	916.00	2,428.00	1,512.00	165.07
2	МОНГОЛ ШУУДАН ХК	168,425	809.88	1,694.00	884.12	109.17
3	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	14,235	403.38	657.00	253.62	62.87
4	МОНГОЛ ШИЛТГЭЭН	1,896	350.00	560.00	210.00	60.00
5	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	3,857,783	166.58	259.70	93.12	55.90
6	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	62,780	110.00	170.00	60.00	54.55
7	ДАРХАН НЭХИЙ	4,627,848	19.52	28.58	9.06	46.41
8	РЕМИКОН	2,863,141	23.34	33.15	9.81	42.03
9	БИ ДИ СЕК	15,856	850.02	1,170.00	319.98	37.64
10	МОНГОЛ САВХИ	131	550.00	740.00	190.00	34.55
11	АВТО ИМПЕКС	79	1,500.00	2,000.00	500.00	33.33
12	ГУТАЛ	73	17,100.00	22,600.00	5,500.00	32.16
13	БУЛГАН УНДРАГА	2,409	4,669.00	6,165.00	1,496.00	32.04
14	СИЛИКАТ	17,924	33.00	41.83	8.83	26.76
15	МОНГОЛ АЛТ	341	21,000.00	26,000.00	5,000.00	23.81
16	МОНИНЖБАР	3,296	94.99	116.67	21.68	22.82
17	ОЛЛОО	153,714	24.67	29.30	4.63	18.77
18	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	1,500	95.00	112.00	17.00	17.89
19	АРД КРЕДИТ ББСБ ХК	19,119,893	216.03	250.23	34.20	15.83
20	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	37,820	1,501.00	1,727.00	226.00	15.06

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-02-28	2021-03-31		
1	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	1,302	850.00	361.00	-489.00	-57.53
2	ТАВ	40	17,800.00	13,750.00	-4,050.00	-22.75
3	СОНСГОЛОН БАРМАТ	9	2,500.00	2,000.00	-500.00	-20.00
4	МОНГОЛ ШЕВРО	97	1,449.00	1,230.00	-219.00	-15.11
5	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	5	4,761.00	4,050.00	-711.00	-14.93
6	СИЛК НЕТ	12	1,250.00	1,065.00	-185.00	-14.80
7	СОР	3,232	600.00	513.53	-86.47	-14.41
8	ХАЙ БИ ОЙЛ	32,053	64.00	58.00	-6.00	-9.38
9	ДОРНОД ХУДАЛДАА	15	20,960.00	19,000.00	-1,960.00	-9.35
10	ЖЕНКО ТУР БЮРО	1,017,211	75.00	69.00	-6.00	-8.00
11	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	40	500.00	460.00	-40.00	-8.00
12	БАГАНУУР	3,945	1,060.00	981.00	-79.00	-7.45
13	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	21,260	657.00	611.01	-45.99	-7.00
14	ТАВАН ТОЛГОЙ	33,641	7,945.00	7,410.00	-535.00	-6.73
15	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	126,879	986.50	925.00	-61.50	-6.23



"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК БОНДЫГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭЖ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛОО



"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготойгоор санхүүгийн зах зээл дээрх хамгийн өндөр үнийн дүн бүхий төгрөгийн болон ам.долларын нийт 2 их наяд хүртэлх төгрөгийн бонд гаргах хүсэлтээ Монголын Хөрөнгийн Биржид 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хүргэсэн билээ.

Уг хүсэлтийг Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо хянаж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А-22 тоот тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 96 тоот тогтоолоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн олон нийтэд нээлттэй санал болгон гаргаж буй 24-36 сарын хугацаатай, нэг бүр нь 100,000 төгрөг болон 100 америк долларын нэрлэсэн үнэтэй, 2 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий бондыг бүртгэж авлаа.



2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Монголын хөрөнгийн бирж дээр "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн

ҮЙЛ ЯВДАЛ

гаргаж буй "ЭТТ Бонд"-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа боллоо.



Энэхүү арга хэмжээнд Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамны дэд сайд О.Батнайрамдал, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн, "Эм Ай Си Си ҮЦК" ХХК-ийн Ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6,440 дэхь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.





“ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИХ” АРГА ХЭМЖЭЭГ 5 ДАХЬ УДААГАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь *Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих*” ёслолын арга хэмжээг 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Бизнес болон тогтвортой хөгжилд жендерийн тэгш байдлын чухлыг олон нийтэд таниулах зорилготой тус арга хэмжээг олон улсын хөрөнгийн биржүүд Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулдаг билээ.

Энэ удаагийн арга хэмжээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Илэйн Конкиевич, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч ноён Ханнес Такач болон МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн хатагтай Л.Болормаа нар оролцож жендерийн эрх тэгш байдлын төлөө нэгдэж, Монголын хөрөнгийн биржийн 6,424 дэх арилжааг нээлээ.

Нээлтийн үеэр, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч хатагтай Илэйн Конкиевич хэлэхдээ, “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийг эмэгтэйчүүдэд анхаарч чиглүүлэхийн тулд, санхүүжилтийн аливаа шийдвэрийг жендерийн өнцгөөс харж, гаргаж буй шийдвэр бүр эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих эсвэл ухраах эсэхийг харгалзаж үзэх нь чухал юм. Иймд, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь МУЗГ-т жендерийн мэдрэмжтэй, үндэсний санхүүжилтийн стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа бөгөөд энэхүү стратегийг боловсруулахдаа хөгжлийн санхүүжилтийн дутагдлыг нөхөх боломжууд, тэр дундаа охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээг онцгой анхаарч байна” гэв.

МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн хатагтай Л.Болормаа

“Эмэгтэйчүүд нь эдийн засгийн хөдөлгөгч хүч хэдий ч бизнес эрхлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна. “Эмэгтэй эзэнтэй бизнес”-ийг тодорхойлох тодорхойлолт болон тоо статистик байхгүйгээс эмэгтэйчүүдийг бизнес эрхлэхэд төр засгаас бодит дэмжлэг үзүүлж чадахгүй байна” гэв.

Жендерийн тэгш оролцоог хангах нь хүний эрх, эрх чөлөөний шударга зарчмыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бизнесүүд, байгууллагууд бүрэн хүчин чадлаа дайчлан ажиллах, ажлын үр дүнг үнэмлэхүй хэмжээнд нэмэгдүүлдэг болох нь дотоод, гадаадын олон судалгаа, практик туршлагаар батлагдсан байдаг. Иймд Монголын

ҮЙЛ ЯВДАЛ

хөрөнгийн зах зээл үүсч, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсан ойн жилд бидний зүгээс жендерийн тэгш оролцоог хангаж ажиллахыг хөрөнгийн зах зээлийн оролцогч бусад байгууллагууд, бүртгэлтэй хувьцаат компаниуд болон гишүүн компаниуддаа хандан уриалж байна.

ЗАРИМ ХУВЬЦААТ КОМПАНИЙГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23 дугаар зүйлийн 23.11 дэх заалтууд болон СЗХ-ны 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн №126 тоот тогтоолыг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/25 тоот тушаалаар СЗХ-ны Үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах тогтоол гарсан “Анод” ХК, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны шалгуур, шаардлага хангахгүй байгаа “Агротехимпекс” ХК, “Дорнод” ХК, “Нийслэл өргөө” ХК, “Шим” ХК, “Хуртай” ХК-иудыг тус тус Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн бүртгэлээс хаслаа.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ НЬ 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци 2020 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан болон Баян Хөндий Алтны Төслийн талаар олон нийтэд мэдээллээ. Өнгөрсөн жил “Ковид-19 цар тахлын нөлөөллийг үл харгалзан Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх гол зорилтуудын хүрээнд үр дүнтэй ажилласан бөгөөд 2020 оны 10-р сард Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай (“EDC”) санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурсан ба нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэснээр уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн дийлэнх хөрөнгийг төвлөрүүлэх боломжтой болсон байна.

Мөн уурхайн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны дундуур бүтээн байгуулалт эхлүүлэх шийдвэрийг гаргахаар төлөвлөж байна.



2020 ОНЫ ЦЭВЭР АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нийт хуваарилах ногдол ашиг / төгрөг/	Нэгж хувьцаанд олгосон ашиг / төгрөг/	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	VIC	"Тандэм инвест" ХК	119,5 сая	0.12	Ээлжит хурлын бүртгэлийн өдөр	2021.12.30-ны өдрийн дотор	ҮЦТХТ
2	CND	"АСБИ" ХК	5,7 сая	90	Ээлжит хурлын бүртгэлийн өдөр	2021 оны 2-р улиралд багтаан	ҮЦТХТ
3	TTL	"Таван толгой" ХК	18,8 тэрбум	357	Ээлжит хурлын бүртгэлийн өдөр	2021.04.21-ний өдрөөс эхлэн	ҮЦТХТ
4	HRD	"Хүрд" ХК	64,7 мянга	479	2021.03.22	2021 оны 2-р улиралд багтаан	ҮЦТХТ
5	BRC	"Барилга	20,3 сая	500	Ээлжит хурлын бүртгэлийн өдөр		Компанийн байранд

"ЭРДЭНЭС СОЛЮШИНС" ХК НЬ "МӨНГӨН МОРЬ" ХХК-ИЙН 85 ХУВИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВСАН БАЙНА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй "Эрдэнэс сольюшинс" ХК нь барилга угсралтын "Мөнгөн морь" ХХК-ийн энгийн хувьцааны 85 хувийг худалдан авч 2021 оны 3-р сарын 02-ны өдөр УБЕГ-т бүртгүүлсэн байна.

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА ИРҮҮЛЭЭГҮЙ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1.6, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтад заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх шаардлагатай байсан хэдий ч Татварын ерөнхий газраас ААН-ийн тайлан хүлээн авах хугацааг 2021 оны 2-р сарын 26-ны өдрийг хүртэл сунгасан билээ. Энэ хугацаанд нийт бүртгэлтэй 192 хувьцаат компаниас нэр бүхий 95 компани нь олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж МХБ-д санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол 97 компани хуулийн хугацаандаа үүргийн хэрэгжилтийг хангаагүй байна.

Хуулинд заасан хугацаанд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нэр бүхий хувьцаат компаниуд **2020 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн дотор зөрчлийг арилгаагүй тохиолдолд СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам", МХБ-ийн холбогдох журмууд болон "Бүртгэлийн гэрээ"-нд заасны дагуу хариуцлагын арга хэмжээг ногдуулахыг анхааруулж байна.**

"АРД КАПИТАЛ ГРУПП ҮЦК" ХХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн № 75 тоот тушаал, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захиралын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/23 тоот тушаалын дагуу Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй "Ард капитал групп ҮЦК" ХХК оноосон нэрийг "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК болгон өөрчилсөн бөгөөд компанийн оноосон нэрийн өөрчлөлт, шинэчилсэн дүрмийг холбогдох хууль, журмын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газарт бүртгүүлж, СЗХ-нд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг үүрэг болгосон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN